

**“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН 2016 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Үнэт цаас гаргагчийн нэр:	“Хай Би Ойл” Хувьцаат Компани
Үнэт цаас гаргагчийн хаяг:	
Оффис:	Үйлдвэр:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, залуучуудын өргөн чөлөө, 27/1 байр 407 тоот Холбоо барих утас: 70112205, 99098989	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон

Улсын бүртгэлийн тухай товч мэдээлэл

Компанийн нэр:	“Хай Би Ойл” ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2007.12.27
Улсын бүртгэлийн дугаар:	9010001063
Регистерийн дугаар:	2615134
Үйл ажиллагааны чиглэл:	- Техникийн тосны үйлдвэрлэл - Гадаад, дотоод худалдаа
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	327 хувьцаа эзэмшигчидтэй. /2016 оны 3 сарын 18-ны өдрийн тархалтын судалгаа/

Компанийн танилцуулга

“Хай Би Ойл” ХК нь Монголд анх удаа техникийн ажилласан тосыг цэвэршүүлэн эдийн засгийн эргэлтэнд оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэр байгуулахаар Хонг Конгийн DUNWELL GROUP.,LTD компанийн 200 тонн ажилласан тос боловсруулах хүчин чадалтай VSEP технологийн V-MAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг оруулан ирж, Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах өөрийн үйлдвэрийн талбайд 2008 оны 9 сард бүрэн угсарч дууссан. Улмаар 10 сараас үйлдвэрийг бүрэн ажиллагаанд оруулсан боловч 1 сарын хугацаанд ажиллаад эрчим хүчний таслалтаас үүдэн үйлдвэрийн гол дамжлага болох мембаран шүүлтүүр VMAT I-36 нь бохирдож үйлдвэр явуулахад хүндрэлтэй болж, уг шүүлтүүрийг сольсноор буюу 2010 оны 5 сараас бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлснээс хойш хэвийн ажиллаж байна.

Үйл ажиллагааны танилцуулга

“ХайБиОйл” ХК нь өнөөдрийн байдлаар нийт 8 ажилчинтайгаар Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VSEP технологийн VMAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг ашиглан өөрийн орны уул уурхай болон бусад салбарын техник тоног төхөөрөмжнөөс гарч буй хаягдал тосыг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Бид өөрсдийн бүтээгдэхүүний түүхий эдийг авто машины тос солих цэгүүд, уул уурхайн компаниуд, газар тариалангийн компаниуд зэргээс хямд үнээр худалдан авч түүнийг боловсруулан Монгол улсын чанарын шаардлагад нийцсэн M-100 маркийн мазут түлш, И-20 төрлийн гидрийн шингэн зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргаж байна.

Бидний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь олон улсад итгэмжлэгдсэн “Амбер” лабораториор баталгаажин гарч байна.

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

2016 оны эхний хагас жилд тосны үйлдвэрлэл болон боловсруулах тоног төхөөрөмжид онцын ноцтой буюу гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажиллаж байна. Тайлант хугацаанд бид нийт 454'172 литр үйлдвэрийн үндсэн түүхий эдийг 7 гэрээтэй байгууллага болон хувь хүнээс цуглуулсан ба үүнд 130'848'627 төгрөгийн зарлага гарч, нэг литр ажилласан маслыг дунджаар 278,2 төгрөгөөр худалдан авсан байна.

№	Түүхий эд худалдан авсан газар	Түүхий эдийн хэмжээ /литр/	Түүхий эдийн үнэ /төгрөг/
1	Аж ахуйн нэгж	222'417	61'382'127
2	Хувь хүн	231'755	69'466'500
Нийт дүн		454'172	130'848'627

4-р сараас эхлэн тос боловсруулах үйлдвэр ажилласан ба тайланд хугацаанд 354'551 л бохир тосыг дахин боловсруулалтанд оруулж, 297'790.5 литр мазут буюу НӨАТ орсон үнээр 250'491'750 төгрөгийн борлуулалт хийгээд байна. Хүснэгтээр харуулбал:

Тайлант хугацааны борлуулалтыг өмнөх оны эхний хагас жилийн хугацаатай харьцуулвал 3 дахин буурсан. Энэ нь АСЕМ-ийн дээд түвшний уулзалттай холбоотой гэж үзэж байгаа. Цаашид 7 сарын 20-ноос хойш мазутын борлуулалт буурах магадлалтай байх ба энэ нь шинэ засгийн газар байгуулагдаж үйл ажиллагаа идэвхжих хүртэл хэсэг зогсонги байдалтай байна гэж үзэж байгаа.

Тайлант хугацаанд бидэнд техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон хувь хүмүүс нь цуглуулж буй ажилласан маслаа бэлэн мөнгөөр болон НӨАТУС-ын баримтгүй өгөхийг илүүд үзэж байна. Гиймээс цаашид техникийн хаягдал тос цуглуулахад багагүй бэрхшээлтэй тулгарах болоод байна. 2016.06.30-ны өдрийн байдлаар түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц дараах байдалтай байна.

Түүхий эдийн нөөц 113'527 литр

Боловсруулсан тос /Мазут/ 63'170 литр

Хөрөнгө оруулалт, засаж сайжруулсан зүйлс:

Үйлдвэрт галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны анхааруулах буюу заах самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг хийж, галын сарай болоод галын буланг өөрсдөө гагнаж хийсэн. Мөн үйлдвэрийг эхлүүлэхэд хуучирч хатуурсан уян шугам хоолойг шинэчлэсэн. Үйлдвэрийн хөргөлтийн насос болон бэлэн бүтээгдэхүүний гадна савнаас

мазут ачих насосууд эвдэрчсэн учир дахин ороолгож засуулан сольсон байгаа. Насосыг солиход шугам хоолойд бага зэргийн засвар орсон байна.

Энэ жилээс үйлдвэрийн хашаан дотор 20 настай 5 ширхэг гацуур модыг худалдан авч тариж ургуулж байна. Худалдагч тал уг модны арчилгаа, заавар, зөвлөгөөг өгч хөрсөндөө сайн бэхжих хүртэл хамтарч ажиллаж байна.

Ажилчдын унаа машин болон тосны цистернд ээлжит урсгал засвар, улсын үзлэг, оношилгоонд хамруулж, АТБӨЯТХ-ийн татвар, хот дотор явах түр зөвшөөрлийг 4 сарын дундаас 2016 оны хагас жил дуусах хугацаагаар авсан болно. Мөн оффисын бичиг хэрэглэл, принтерийн хор, цэвэрлэгээний материалд болон бусад материалд зарцуулсан зардлын задаргааг харуулбал:

№	Материалын нэр	Зардал /төгрөг/
1	Цахилгааны төлбөр	19'072'247₮
2	Автомашин, автоцистерны үзлэг оношилгоо, шатахуун, засвар, сэлбэг, хот доторх зөвшөөрөл	1'531'364₮
3	Бусад материалд /тос арчих материал, мазут шинжилгээ г.м/	1'394'729₮

Он дуустал хийгдэх зүйлс болон борлуулалтын таамаглалын тухайд:

2016 оны эхний хагас жилд шинээр мазут худалдан авагч “Тэгшт плант” ХХК, “Эко асфальт” ХХК, “Дэвжих-Эрдэнэ” ХХК зэрэг 3 хэрэглэгч нэмэгдэж байна. Эдгээр нь он дуустал гэрээ хийсэн бөгөөд гэрээний дагуу төлбөр оруулаагүй тул “Тэгшт плант” ХХК болон ”УВТ инвест” ХХК-дад мазут нийлүүлэхийг түр зогсоогоод байна. Үлдсэн хагас жилд захиалгын дагуу дээрх байгууллагуудад ойролцоогоор 750 тонн мазут авахаар байгаа боловч өнөөгийн улс төрийн нөхцөл байдал буюу сонгууль, шинэчлэсэн засгийн газар, замын компаниудын санхүүжилт зэргээс шалтгаалан удаашрах магадлалтай байна. Бид захиалагч байгууллагын итгэлийг алдахгүйн тулд нэн түрүүнд үйлдвэрлэлд шаардагдах техникийн хаягдал тосыг бэлэн нөөцтэй байлгах арга хэмжээнүүдийг дор бүр авч шуурхай ажиллана.

Үлдсэн хагас жилд дараах ажил үйлчилгээнүүдийг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. 60-27 УНП автоцистерны сүүлийн хагас жилийн ЕС болон хот доторх зөвшөөрөл.
2. ОО-ын нүх ухаж, жорлонг шинэчлэх.
3. Үйлдвэрт шаардлагатай галын булан, галын сарай хийх.
4. Үйлдвэрийн гадна хаягийг шинэчлэх.
5. Лагийн ууршуулах талбайн тооцоо гаргах, хийх.
6. Тосны агуулахад бетонон шаллагаа, далан хийх төсөв тооцоог гарган хэрэгжүүлэх.
7. Тос агуулах савнуудын тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны зааварчилсан самбар, хэмжээс, калибровкийг шинэчлэн хийлгэж баталгаажуулах, орчныг тохижуулах ажил.
8. Байгаль орчны менежментийн төсөв, төлөвлөгөөг боловсруулж харьяа дүүрэг, хороотой холбогдох гэрээ хэлэлцээрийг шинэчлэх хийх.
9. БОНБУнэлгээ, гамшигийн үнэлгээг хийлгэх.
10. Өвөлжилтийн бэлтгэл ажил эхлүүлэх.









Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

2016 оны эхний хагас жилд 228,391,727 төгрөгийн орлоготой, 160,128,496 төгрөгний өртөгтэй, цалин хөлсний зардалд 138,971,423 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 18,066,285 төгрөг, засвар үйлчилгээний зардалд 1,026,545, бусад үйл ажиллагаанд 79,970,682 төгрөгийн зардал гаргасан байна.

Ажилчдад 86,698,351 төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 42,000,000 төгрөг, ХХОАТатварт 16,400,000 төгрөг, ОАТатварт 4,200,000 төгрөг, газрын төлбөрт 780,120 төгрөг, ҮХЭХАТ –т 5,154,684 төгрөг, НӨАТатварт 19,204,811 төгрөг, аудитын үйлчилгээнд 9,900,000 төгрөг, бараа материал худалдан авахад 107,979,400 төгрөг зарцуулсан байна.

2016 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн хураангуй:			
№	а. Үлдэгдлийн тэнцэл	01 сарын 01	06 сарын 30
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	86,987,870	20,896,229
2	Дансны авлага	1,940,535,103	1,807,887,634
3	Бусад авлага	1,173,252,047	1,231,678,868
4	Бараа материал	47,132,422	88,809,635
5	Урьдчилж төлсөн зардал тооцоо	13,756,366	14,235,317
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,261,663,808	3,163,507,683
7	Үндсэн хөрөнгө	1,398,620,374	1,360,576,376
8	Биет бус хөрөнгө	1,211,590	397,904
9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,058,172,132	5,058,172,132
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,458,004,096	6,419,146,412
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,719,667,904	9,582,654,095
12	Дансны өглөг	191,074,220	192,964,375
13	Цалингийн өглөг	29,105,400	93,386,337
14	Татварын өр	52,361,392	51,118,884
15	НДШ-ийн өглөг	11,482,568	4,436,774
16	Бусад богино хугацаат өр төлбөр	420,660,246	425,573,396
17	Өр төлбөрийн нийт дүн	704,683,827	767,479,766
18	Хувийн өмч	5,211,895,400	5,211,895,400
19	Нэмж төлөгдсөн капитал	4,592,503,138	4,592,503,138
20	Хуримтлагдсан ашиг	(789,414,461)	(989,224,209)
21	Эздийн өмчийн дүн	9,014,984,077	8,815,174,329
22	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,719,667,904	9,582,654,095
	б. Орлого үр дүнгийн тайлан		
23	Борлуулалтын орлого (цэвэр)		228,391,727
24	Борлуулалтын өртөг		160,128,496
25	Нийт ашиг (алдагдал)		68,263,231
26	Хүүгийн орлого		41,413,739
27	Бусад орлого		-
28	Ерөнхий ба удирдлагын зардал		235,983,064
29	Санхүүгийн зардал		-
30	Бусад зардал		2,051,872

31	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(34,783,429)
32	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(163,141,394)
33	Орлогын татварын зардал		4,141,374
34	Татварын дараах ашиг (алдагдал)		(167,282,768)

“Хай Би Ойл”ХК-ийн охин компани


НВОil (L) berhad

“НВОil (L) berhad” нь анх “Ninox hydrocarbons (L) berhad” нэртэйгээр 2011 оны 10 сард байгуулагдаж, Малайз улсад бүртгэгдсэн. Компанийн дугаар: LL08546. “Ninox energy”Ltd –ийн охин компани байсан ба 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар худалдан авах зөвшөөрлийг олгосны дагуу 2013 оны 9 дүгээр сард “Хай Би Ойл” ХК нь худалдан авснаар “Хай Би Ойл” ХК-ийн 100% охин болсон.

НВОil (L) berhad компанийн суурь хөрөнгө нь КОЕС International Inc –ийн хувьцааны 20 хувь бөгөөд 80 хувийг нь Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ)-ын газрын тосны үндэсний компани болох Солонгосын газрын тосны хайгуулын компани /КОЕС/ эзэмшдэг.

КОЕС INTERNATIONAL, INC-ийн бүтэц

Схем 1. КОЕС International Inc-ийн хөрөнгө оруулалтын бүтэц



Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Hermes Petroleum(L)Berhad	33.25%
2	Firebird Mongol Holdings A S.A.R.L	18.86%
3	Firebird Global Master Holdings-2 S.A.R.L	13.01%
4	Triton energy limtied	8%
5	“БиДиСЕК” ХК	6.98%

Ногдол ашгийн талаархи мэдээлэл:

Компани нь 2015 онд алдагдалтай ажилласан ба нэмж хувьцаа гаргасантай холбогдуулан 2015 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл

Компани их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Майк Рего, Д.Даянбилгүүн хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, Сий Кок Хенг, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар дийлэнх хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	дээд
2	Өлзийсайхан овогтой Хүдрээ	Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн ердийн гишүүн,	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
4	Кэйт Беннетт	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
5	Майк Рего	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд

8	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Сий Кок Хенг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хай Би Ойл” ХК **2016 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2016 оны 05 сарын 23-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Пүрэвбаатар, Х.Батхишиг, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Пүрэвбаатарыг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Х.Батхишиг, М.Батсүрэн, Кэйт Беннетт гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Кэйт Беннетт-г томилсон.

“Хай Би Ойл” ХК **2015 оны 04 сарын 30**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

“Хай Би Ойл” ХК **2014 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах